

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/**

2023-12-31


1. Жолоочийн даатгалын сан

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйл, Холбооны удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 2 дугаар тогтоолын дагуу 2023 онд Жолоочийн даатгалын санд 1,493,200.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан ба тайлант хугацаанд дараах байдлаар орлого төвлөрүүлж ажиллалаа.

- ✓ Буцаан төвлөрүүлсэн нөхөн төлбөр 128,274.9 мянган төгрөг
- ✓ Мэдээллийн санг ашиглуулсны орлого 165,464.5 мянган төгрөг
- ✓ Даатгагчдаас 358,569.2 мянган төгрөг
- ✓ Хүүний орлого 1,712,593.1 мянган төгрөг нийт 2,364,928.7 мянган төгрөг төвлөрүүлсэн нь орлогын төлөвлөгөө 158,4 хувийн биелэлттэй байна.

Жолоочийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл дүрслэл/1/-ээр харуулбал:

Дүрслэл 1




Орлогын гүйцэтгэлийн 72 хувийг сангийн хөрөнгийг байршуулсан банкнуудаас орж ирж байгаа хүүний орлого эзэлж байна. Харин Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасан эх үүсвэрийг төвлөрүүлэх эрх зүйн актын төслийг боловсруулж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

Сангийн орлогын гүйцэтгэлийг 2022 оны мөн үетэй харьцуулбал орлогын төлөвлөгөө дараах байдалтай байна.

Орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл, харьцуулалт /сая.төг/

Дүрслэл 2



Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг холбогдох журамд заасны дагуу Төрийн банк, Хаан банк, Голomt банканд 2023 оныг дуустал хугацаатайгаар байршуулж байна. Энэ хугацаанд Удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаартай тогтоолоор “Зам тээврийн мэдээллийн нэгдсэн сан” байгуулахад олгохоор баталсан 10.0 тэрбум төгрөгийг 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Зам тээвэр, хөгжлийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу шилжүүлсэн.

Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банкүүдын хувьд. Чингис хаан

Чингис хаан банк дахь холбооны хадгаламжийн үлдэгдэл нь 5,454,539.8 мянган төгрөг байсан ба тайлант хугацаанд 15,000.0 мянган төгрөг татан авч 5,434,539.9 мянган төгрөг үлдээд байна.

Тус банктай 2020 оны 11 сарын 04-ний өдөр УБ хот, Сүхбаатар дүүргийн, Чингисийн өргөн чөлөө гудамж, 17 байр 13 тоот, 476,7 кв талбайтай оффисын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг 2,181,856.0 мянган төгрөгөөр үнэлэн, харилцан ойлголцож “Өр төлбөрт шилжүүлэх тухай гэрээ”, 2022 оны 05 сарын 12-ны өдөр Албан журмын даатгагчдын холбоо нь “Си эф си” ХХК-ийн өмчлөлийн, Хан уул дүүргийн 3-р хороо, энгелсийн гудамж 8 тоот хаягт байрлалтай 15 давхар оффис, үйлчилгээ, орон сууцны баригдаж буй барилгаас нийт 4,4 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 3 давхарт байрлах 470.9 кв талбайтай үйлчилгээний заал, 7 давхарт байрлалтай 362,9 кв талбайтай оффисын өрөөг мөнгөн хөрөнгөнийхөө үлдэх хэсэгт тооцон авахаар банк уг барилгын эзэнтэй 3 талт гэрээг/ Чингис хаан банк, Си эф си” ХХК/ -тай тус тус байгуулсан.

Үндэсний хөрөнгө оруулалтын банк 2022 оны 12 сарын 31-ний өдрийн Тус банкны Үлдэх 326 285.6 мянган төгрөг байсан. Үүнээс тайлант хугацаанд 85,000.0 мянган төгрөг татан авч үлдэгдэл 241,285.1 мянга төгрөг байна.

Санхүү бүртгэл

Холбооны 2022 оны жилийн эцсийн болон 2023 оны 1, 2,3 дугаар улирлын санхүү, нийгмийн даатгал, татварын тайлангуудыг нэгтгэн гаргаж эрх бүхий газруудад тогтсон хугацаанд нь багтаан хүргүүлсэн. 2022 оны санхүүгийн тайланд “Си Эс Ай аудит” ХХК-аар аудит хийлгэж дүгнэлтийг СЗХороо, Удирдах зөвлөлийн гишүүдэд хүргүүлэн, олон нийтэд мэдээлсэн.

Ажилчдын сар бүрийн цалин хөлсний тооцоог хийж, Нийгмийн даатгалын байгууллагатай харилцаж, сар бүрийн тайлан болон тайлант хугацаанд ажилтнуудтай холбогдох тооцоог хийж тооцоо нийлэн нэхэмжилж ажиллав.

Холбооны орлого буюу 2023 оны гишүүний татвар тогтсон хугацаанд 15 гишүүн даатгагчдаас 15,0 сая төгрөг бүрэн төвлөрлөө.

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

мянган төгрөгөөр

Д.д	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31		2023 оны 12-р сарын 31	
		ДТ	КТ	ДТ	КТ
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	294,063.7		74,600.2	
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт	26,676,178.8		17,539,046.8	
3	Авлага	173,389.6		407,965.6	
4	Үндсэн хөрөнгө (Цэвэр)	1,791,782.9		1,638,683.9	
5	Биет бус хөрөнгө (Цэвэр)	160,230.9		124,956.9	
6	Дансны өглөг				2,303.4
7	Цалингийн өглөг				
8	Татвар хураамжийн өглөг		327.2		280.0
9	Жолоочийн даатгалын сан буюу хязгаарлалттай нөөц		29,070,653.2		19,769,857.0
10	Хязгаарлалтгүй нөөц буюу холбооны өөрийн хөрөнгө		24,665.5		12,813.0
	ДҮН	29,095,645.9	29,095,645.9	19,785,253.4	19,785,253.4

Нөхөн төлбөр

Жолоочийн даатгалын сан нь тайлант хугацаанд 43 нөхөн төлбөр хүссэн өргөдөл хүлээнч авч холбогдох эрх зүйн актуудын шаардлагыг хангуулж 39 өргөдлийг хянан гэрээг байгуулж 167,478,450 төгрөгийн нөхөн төлбөрийг даатгалын тохиолдлын хохирогчдод олгож, буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх ажиллагаа хийгдэж байгаа бол хянагдаж байгаа 4 нөхөн төлбөрийн материал байна. Нөхөн төлбөрийн өргөдөл шийдвэрлэлт 100 хувь байна.

Даатгалын сан болон шуурхай албаны зүгээс нөхөн төлбөрийн буцаан төлөлүүлэх ажлыг эрчимжүүлэн буцаан төлөх гэрээний хугацаа дууссан, төлөлтөө гэрээнд заасан хугацаанаас илүү сараар тасалдуулсан этгээдүүдийг эрэн сурвалжлах, хууль хяналтын байгууллагад өргөдөл гомдол гаргах, шүүхэд нэхэмжлэх гаргах, Монгол банкны зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэх зэрэг 40 иргэнд холбогдох ажлуудыг шат дараатайгаар зохион байгуулж ажиллалаа. Тухайлбал, тайлант хугацаанд цагдаагийн байгууллагад хүсэлт, мэдэгдэл өгснөөр эрэн сурвалжилж илрүүлсэн 10, шүүхийн шийдвэрээр эрэн сурвалжлагдаж буй 5, шүүхэд нэхэмжлэл гаргасан 3, биечлэн дуудаж уулзсан 4, дахин шүүхэд хандсан 5,

батлан даагчийг эрэн сурвалжилсан 5, хилээр гарсан эсэхийг тодорхойлуулах хүсэлт гаргасан 2, нас барсан иргэн 5 байна.

Дүрслэл 4

Нөхөн төлбөрийн авлагын дүн /2013-2023 он/

													2023.12.31	
Он	Олгосон нөхөн төлбөр		Нөхөн төлбөрийн авлага		Үүнээс:									
					Хугацаа хэтэрсэн		Хугацаандаа байгаа		Нас барсан		Гэрээгүй			
	Хүний тоо	ДҮН	Хүний тоо	ДҮН	Хүний тоо	ДҮН	Хүний тоо	ДҮН	Хүний тоо	ДҮН	Хүний тоо	ДҮН		
2013	19	40,544,132	1	2,017,110	1	2,017,110								
2014	64	150,724,960	9	17,391,810	9	17,391,810			1	1,680,000.00				
2015	49	113,984,504	4	3,108,200	4	3,108,200			1	1,165,400.00				
2016	64	157,129,540	7	7,297,400	7	7,297,400			1	300,000.00				
2017	30	74,533,661	2	2,634,292	2	2,634,292			1	312,000.00				
2018	6	7,325,500												
2019	1	4,000,000	1	2,000,000	1	2,000,000								
2020	5	6,715,000												
2021	9	36,782,130	1	4,074,000	1	4,074,000					1	4,074,000		
2022	43	140,087,485	17	35,934,585	17	35,934,585					2	3,175,085		
2023	43	167,478,450	39	112,830,700	4	12,780,900	35	100,049,800	1	5,000,000	1	5,000,000		
	333	899,305,362	81	187,288,097	46	87,238,297	35	100,049,800	5	8,457,400	4	12,249,085		

2. Жолоочийн даатгалын мэдээллийн сан

Жолоочийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой мэдээллийг төвлөрүүлэн нэгтгэх, хяналт тавих үндсэн үүрэгтэй мэдээллийн сан үндсэн үүргээ өөрийн боловсруулж нэвтрүүлсэн МИИС системийг ашиглан хэрэгжүүлж байна.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн Дата өгөгдлөөр нэгдсэн тайлан дүн, мэдээг улирал тутам өссөн дүнгээр гаргаж нэгтгэдэг. Үүнд:

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компаниуд тайлант хугацаанд 807,287 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 45,614,586,232 төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн.

Холбооны даатгалын сангаас болон гишүүн 15 даатгалын компаниас 2023 онд нийт 28,992 жолоочийн даатгалын тохиолдол гарч 32,173,672,649 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Хохирлыг эрсдлийн ангилал тус бүрээр хувьд авч үзвэл тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан 28,408 даатгалын тохиолдолд 31,217,384,281 төгрөгийн нөхөн төлбөр, бусад хөрөнгөд хохирол учруулсан 437 даатгалын тохиолдолд 686,493,649 төгрөгийн нөхөн төлбөр,

бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан 147 даатгалын тохиолдолд 269,794,719 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Хувь хүний 574,200, хуулийн этгээдийн 208,281, мэргэшсэн болон CD ангиллын жолоочийн 17,835, дамжин өнгөрөхийн 6,971 гэрээ бүртгэгджээ. Хувь хүний жолоочийн даатгалын 19,757 гэрээ, хуулийн этгээдийн 11,864 гэрээ, мэргэшсэн C, D ангиллын 1,135 гэрээ, дамжин өнгөрөх 58 даатгалын гэрээ цуцлагдсан.

Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 32 зуучийн компани 2023 оны жилийн эцсийн байдлаар 288,148 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 16,042,436,412 төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн. Нийт хураамжийн дүнд эзлэх хувь 33,6% байна.

Мэдээллийн сангийн мэдээллийг боловсруулж, гишүүн 15 даатгалын компаниас МИИС системд нийлүүлсэн даатгалын хүчинтэй гэрээний тоо, хураамжийн орлого, олгосон нөхөн төлбөрийн тоо, дүн зэрэг мэдээллийн зөрүү тайлан мэдээ, танилцуулга нэгтгэж боловсруулахад шаардлага хангахгүйгээс тулгалт хийж даатгалын компаниудын гэрээ, нөхөн төлбөр хариуцсан ажилтнуудад мэдээллээ нягталж оруулах шаардлага тавьж мэдээллийн сангийн журам, МИИС систем ашиглах гэрээний үүргээ биелүүлж, үнэн зөв тайлан гаргах, мэдээллийн санд нийлүүлэх тухай анхааруулж, зарим даатгалын компаниуд руу албан бичгээр шаардлага хүргүүллээ.

Профешнл иншурэрс партнер ХХК даатгалын зуучлагчийн жолоочийн даатгалын гэрээ хийх хүсэлт, материалыг хүлээн авч, Хороонд ирсэн гомдлын хариу шийдвэр гарах хүртэл МИИС систем ашиглах хүсэлтийг хүлээн авах боломжгүй байгаа талаар албан бичгээр мэдэгдэж, Мэдээллийн сангийн мэдээлэл ашиглуулах журамд заасны дагуу сүүлийн 2 сар гэрээ байгуулаагүй болон үйл ажиллагаа нь зогссон даатгалын Ариг банк, Капитрон банк, Ренессанс групп ХХК, Соёмбо Ай Би ХХК, Улаанбаатар хотын банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Хүннү Сиэл ХХК, Эй Эс Ай Би ХХК, Эм Эн Ай Би ХХК зэрэг зууч компаниудын МИИС систем ашиглах эрхийг хаасан. Энэ тухай албан бичгийг СЗХ, Монголын зуучлагчдын холбоонд хүргүүлсэн.

Миг даатгал ХХК-ийн төлөөлөгч 2022 оны 07-р сарын 04-ний өдөр 2166УНН улсын дугаартай TOYOTA PRIUS-30 маркийн авто машины АЖЖХДаатгалын 22020119114951 тоот гэрээг байгуулахдаа 2021 онд хийгдсэн буруу регистрийн дугаартай даатгуулагчийн гэрээг үндэслэн хийсэн тул тус тус гэрээний эзэмшигчийн буруу регистрийн дугаар /РД: ЦБ75051904/-ийг зөв РД: ШД76120102 болгож засварлаж өгөх хүсэлтийг авч мэдээллийн санд шалган өөрчлөлт оруулахыг зөвшөөрч гэрээ хийсэн ажилтанд мэдээллийн санд буруу мэдээлэл нийлүүлэхгүй байх талаар анхааруулга өглөө.

Жолоочийн даатгалын мэдээллийн санг дараа үеийн технологид түшиглэн цогц систем болгох зорилтын хүрээнд цахимаар даатгал хийх боломж олгохоор Монгол даатгал ХХК-тай гэрээ байгуулж ажилласнаар даатгуулагчид ДАН системээр өөрийгөө таниулан цахимаар хувь хүн, мэргэшсэн жолооч эсэхийг сонгож жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдах боломжтой боллоо. Ард даатгалтай байгуулсан цахимаар даатгал хийх гэрээний дагуу мэдээллийн санд хийгдсэн хөгжүүлэлтийг тухайн тохиолдолд ашиглах өөрчлөлийг нэмэлтээр оруулж тест ажлыг хийв. Юпланет ХХК ний ирүүлсэн жолоочийн даатгалын гэрээг цахимаар хийх шийдлийг судалж тус шийдэлд холбогдох өөрчлөлийг оруулан хамтран ажиллах гэрээг байгуулав. Мөн “Асимон зууч” ХХК гар утас, пос машин дээр жолоочийн даатгал хийх боломжийг эрх зүйн орчинд нь нийцүүлэн гаргаж хамтран ажиллах гэрээ

байгуулан жолоочийн хариуцлагын даатгалыг цахимаар хийх хөгжүүлэлтийг мэдээллийн сангийн МИИС системд нэмэлтээр оруулан хөгжүүлэлт хийж ашиглалтанд оруулав.

Оракл RAC болон бусад дагалдах программ хангамжийг лицензлүүлэх ажлын хүрээнд, Мэдээллийн санд Оракл программын дэмжлэг үзүүлэх суппорт сунгалтыг худалдан авах тендерийн ажлын хэсэг байгуулан тендер зарлаж оролцсон компаниудын материалуудыг хүлээн авч, сонгон шалгаруулж гэрээ байгуулан холбогдох бичиг баримтууд, хурлын тэмдэглэл хөтлөн архивласан.

Мэдээллийн сангийн сервер төхөөрөмжүүдийн мониторинг системийн PRTG Network monitor, Cisco ASDM, VirtualVM программуудын тусламжтайгаар сервер төхөөрөмжүүдийн ажиллагаанд өдөр бүр хяналт тавин системийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Хэрэглээний программ “Microsoft Office 365” -ын лиценз авах, түүнтэй холбоотой гэрээ болон сүлжээний үндсэн гарц, /Fortigate 100F/ хамгаалалтын төхөөрөмжийн лиценз сунгалт хийхтэй холбогдуулан холбогдох хүсэлтийг ITZONE ххк-д гаргаж лицензийн нийлүүлэлт, суурилуулалт, системийн тохиргоо, бусад шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Байгууллагын ашиглаж байгаа интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, сүлжээний ачаалал даах чадамжийг сайжруулах зорилгоор Mobinet ххк-д холбогдох хүсэлтийг гаргаж интернэтийн үндсэн гарцын урсгалын хурдыг 6mbps байсныг 50mbps болгож нэмэгдүүлэн ажилласан байна. Холбооны 13 давхарт байрлах оффисоос 2023 оны 02-р сарын 22-ны өдөр ус алдсаны улмаас байгууллагын ажилчдын зарим компьютер, принтер, дагалдах төхөөрөмжүүдэд ус орж гэмтсэн учир тэдгээрийг засварлах, хэвийн ажиллагаанд оруулах, холбогдох байгууллагуудад хандан дүгнэлт гаргуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Серверийн өрөөний UPS төхөөрөмжийн battery-г шинэчлэн сольсонтой холбогдуулан UPS төхөөрөмжүүдийн сүлжээний тохиргоог өөрчлөх, дотоод сүлжээнд холбох, удирдлагын программын шинэчлэлтийг /upgrade/ хийж хэвийн ажиллагаанд оруулсан. Иргэдийн өргөдлийн дагуу 4 жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалт болон нөхөн төлбөрийн лавлагаа гаргаж Ай ай би ХХК, Дархан Шаркс ХХКомпаниудаас ирүүлсэн зуучлагчаар бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч шаардлагатай, дутуу бичиг баримтуудыг танилцуулан мэдээллээр хангаж ажиллалаа. Санхүүгийн зохицуулах хороонд сар бүр даатгалын компаниудын жолоочийн даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн тайлан мэдээг илгээж даатгалын зуучлагчдын байгуулсан гэрээний мэдээллийн тайланг жолоочийн даатгалын санд гаргаж өгөв.

“Монголиан актуариал консалтинг сервис” ХХК-ийн Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүрийн актуар тооцоололд үнэлгээ, судалгаа хийх ажлын хүрээнд 2016-2023 онуудын даатгалын гэрээ болон нөхөн төлбөрийн мэдээг гаргаж өгч ажиллалаа.

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар Холбооны www.ami.mn цахим хуудсаар, давхардсан тоогоор 80,161 иргэн нийт 2,623,025 хандалт хийж Холбооны мэдээллүүдтэй танилцжээ.

3. Шуурхай алба

Жолоочийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д заасны дагуу жолоочоос шалтгаалан гарсан зам тээврийн ослын талаарх мэдээллийг даатгуулагч, даатгагч,

жолооч, хохирогч, иргэнээс хүлээн авч, даатгалын тохиолдлын улмаас хохирогчид олгох нөхөн төлбөрийг шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Сангийн шуурхай алба нь жолоочийн даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дуудлагын ажилтан ажиллуулах, даатгалын тохиолдлын газар дээр шуурхай очиж үзлэг хийх, тэмдэглэл үйлдэх, даатгалын тохиолдол болсныг баримтжуулах, даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгох нөхөн төлбөрийг үнэн зөв, тодорхойлж ажилладаг. Өөрөөр хэлбэл зам тээврийн осол /ЗТО/-ыг даатгалын тохиолдол мөн эсэхийг тодорхойлж шаардлагатай арга хэмжээг авч, зөвлөгөө мэдээллээр даатгагч, даатгуулагч, жолооч, хохирогчдыг үнэн зөв, тэнцвэртэй мэдээллээр хангах үүрэг хүлээдэг. Мөн, даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа дууссан жолооч зам тээврийн ослын улмаас бусдад хохирол учруулсан тохиолдолд даатгалын тохиолдлын газар дээр ажиллаж, хуульд заасан хугацааны дотор хүүгүй, барьцаагүй нөхөн төлбөрийг жолоочийн даатгалын сангаас гаргаж, хохирогчийг хохиролгүй болгох, Жолоочийн даатгалын тухай хуулийн 20.2-т зааснаар жолоочийн даатгалын санд эргүүлэн төлөх талаар ойлгуулан нөхөн төлбөр авах тохиолдолд буруутай этгээдтэй гэрээ хийж буцаан төлөлтийн хэрэгжилтийг хангадаг.

Дуудлагын нэгдсэн төв /ДНТ/-ийн 18001177, 70101177 дугаарт **4214** дуудлага хүлээн авч МИИС программд бүртгэж, бусад мэдээллийн чанартай дуудлага хүлээн авч зохих мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.

Дуудлагын тоог ангилж үзүүлбэл:

ДТ-н дуудлага	Хууль тогтоомжийн Лавлагаа	МС-ийн лавлагаа	ДС-ийн НТ-н лавлагаа	Санал гомдол	ДК-ийн утас, байршил	Бусад	Нийт
73	117	2638	274	6	810	296	4214

Жолоочийн хариуцлагын даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авах нэгдсэн төвийн тусгай дугаарт нийт 71 даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авч МИИС программд бүртгэн ажиллалаа. Сангийн 73 дуудлага бүртгэснээс сангаас 43 жолооч нөхөн төлбөр гаргуулж, бусад дуудлага 30 нь хоорондоо зохицсон. Тайлант хугацаанд Шуурхай албаны дуудлагын нэгдсэн төв, даатгалын компаниудын операторууд нийт даатгалын тохиолдлын 1,456 дуудлагыг МИИС системд бүртгүүлснээс нийслэлд 80,7%, орон нутагт 19,3% нь тус тус бүртгэгдсэн байна. Нийслэлд бүртгэгдсэн даатгалын тохиолдлын дуудлагын 3% нь алслагдсан, 19% нь Баянзүрх, 17% нь Сүхбаатар, 7% нь Чингэлтэй, 20% нь Баянгол, 19% нь Хан-Уул, 19% Сонгинохайрхан дүүрэгт тус тус бүртгэгджээ.

Энэ онд даатгалын санд 127,064,398 төгрөгийн буцаан төлөлт хийгдэж, нийт 39 үүрэг гүйцэтгэгч төлбөрөө бүрэн төлж барагдуулсан байна.

4. Сургалт, сурталчилгаа

2023 онд сургалт сурталчилгааны ажлын хүрээнд сургалтын төлөвлөгөө боловсруулж гүйцэтгэлийг ханган ажиллалаа. Үүнд:

Санхүүгийн зохицуулах хорооноос санаачлан хэрэгжүүлж буй даатгалын ач холбогдлыг иргэдэд нэгдсэн байдлаар хүргэх, салбарын нэр хүнд, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Даатгал 89” арга хэмжээнд нэгдэж ажиллаж байна. Тус арга хэмжээний

хүрээнд цахим сурталчилгааны материаллуудыг бэлтгэж холбооны цахим хуудсууд болон хамран ажилладаг байгууллагуудаар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Сургалт сурталчилгааны дээр дурьдсан төлөвлөгөөний дагуу 9 сарыг хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх аяныг гишүүдийн хамт зохион байгуулж ажилласан.

Тээврийн цагдаагийн албанаас санаачлан хэрэгжүүлж буй “Нэг зам-нэг соёл” нөлөөллийн арга хэмжээг Жолоочийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4 дэхь заалтыг үндэслэж, Удирдах зөвлөлөөс баталсан сургалт, сурталчилгааны төсвийн хүрээнд хамтран ажиллаж уг аянд 50,000.0 мянган төгрөгийн санхүүжилт 50 ширхэг мэдээллэх самбар хийлээ.

Тайлант хугацаанд Ийгли бродкастинг телевиз, Монгол телевиз, NTV телевиз автордио 96.3д Жолоочийн даатгал 2022 оны тоон мэдээ статистикаар мэдээ ярилцлага өглөө.

Тайланд хугацаанд нийт зорилтот бүлгүүд рүү чиглэсэн дараах сургалтуудыг зохион байгуулж ажиллалаа.

- Монголын авто тээврийн нэгдсэн холбоотой хамтран улсын хэмжээнд үйл ажиллагааг явуулж буй техникийн хяналт, оношлогооны төвүүдийн мэргэшсэн болон инженерүүдэд “Даатгал ба эрсдэл, Жолоочийн даатгалын ач холбогдол” сэдвээр 2 удаагийн сургалт
- “Авто сургуулиудын арга зүйн төв”-тай хамтран Жолоодох эрхээ хасуулсан иргэдэд “Жолоочийн хариуцлагын даатгал, түүний ач холбогдол, зам тээврийн ослын үед авах арга хэмжээ ” сэдвээр 3 удаагийн сургалт
- Санхүүгийн зохицуулах хороо, Тээврийн цагдаагийн алба, Ард даатгалтай хамтран Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-н 1,2,3 дугаар баазын жолооч, санхүү эрхэлсэн ажилтнууд, удирдлагад “ Эрсдлийн удирдлага, даатгалын зарчим”, “Жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдол”, зэрэг сэдвээр
- Санхүүгийн зохицуулах хороо, Авто сургуулиудын нэгдсэн холбоотой хамтран Жолоодох эрхээ хасуулсан иргэдэд сургалтын үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагуудын сургагч багш нар, захирлуудад “Эрсдэлийн удирдлага, даатгалын зарчим, Жолоочийн хариуцлагын даатгал, анхаарах асуудлууд, Албан журмын даатгагчдын холбооны талаарх мэдээлэл, “Жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдол”, “Даатгалын тохиолдлын үед авах арга хэмжээ” сэдвийн хүрээнд мэдээлэл өгч, хэлэлцүүлгийг өрнүүлсэн. Уг арга хэмжээнд “Зөв сургалт хөгжлийн төв”, “Зөв хөдөлгөөн”, “Чөлөөт урсгал”, “Тод зорилт ” зэрэг сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг 24 байгууллагаа төлөөлөл оролцсон.
- Таксины нэгдсэн үйлчилгээ эрхэлж буй “Ubcab”-тай хамтран долоо хоног бүр тус байгууллагад бүртгэлтэй жолооч нарт Жолоочийн хариуцлагын даатгал, түүний ач холбогдол, зам тээврийн ослын үед авах арга хэмжээ ” сэдвээр сургалтыг явуулж байна.

Дээрх зорилтот бүлгүүдэд Жолоочийн даатгалын хуулийг дэлгэрүүлэн тайлбарлаж хүргэснээр Даатгалд хамрагдалд нэмэгдэх, Даатгалын тохиолдлын үед талуудын оролцоо, хуулийн мэдлэг, даатгалын ач холбогдлыг мэдрүүлэх, цаашлаад даатгалын тохиолдлыг бууруулах ач холбогдолтой юм.

Контент агуулга сэдэв	Зорилтот бүлэг	9 сар	10 сар	11 сар	12 сар
Зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах	ЕБС сурагчдад	10		5	
ЖХАЖД-д даатгуулахдаа юуг анхаарах вэ	Тээврийн хэрэгслийн өмчлөгч жолооч нарт		5		5
ЖХАЖД-д даатгуулсан этгээд ямар үүрэг хариуцлага хүлээх ёстой вэ	Тээврийн хэрэгслийн өмчлөгч жолооч нар		5	5	
Зам тээврийн ослын үед юуг анхаарах вэ	Тээврийн хэрэгслийн өмчлөгч жолооч нар		5		5
Нөхөн төлбөр	Тээврийн хэрэгслийн өмчлөгч жолооч нар		5	5	
ЖХАЖД ба Тээврийн хэрэгслийн даатгалын ялгаа	Тээврийн хэрэгслийн өмчлөгч жолооч нар			5	5
Хариуцлагын даатгалын статистик мэдээлэл	Олон нийгэд		5	5	5

Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хянасан нь: 1. Удирдах зөвлөлийн 4 дүгээр сарын 21-ний өдрийн 2 дугаар тогтоолоор орон нутаг дахь салбарыг татан буулгаж орон нутагт ажиллаж байсан менежерүүдэд Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасантай нийцүүлэн 2-5 сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмжийг олгож 56,5 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй эд хөрөнгийг зах зээлийн үнэлгээгээр 148,4 сая төгрөгөөр үнэлж 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 13 автомашин 74,820,000.00 төгрөгөөр худалдан борлуулсан, 7 автомашин худалдагдаагүй Улаанбаатар хотод хадгалагдаж байна. Салбаруудад ашиглагдаж байсан, эвдэрч гэмтсэн, цаашид ашиглах боломжгүй, актлах шаардлагатай боловч элэгдлийн хугацаа дуусаагүй, ашиглалтын хугацааг олон жилээр бүртгэлжүүлсэн 1,8 сая төгрөгийн эд хөрөнгө хадгалагдаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн санд тус холбооны орон нутаг дахь салбаруудыг татан буулгасан хасалт хийлгэж Гүйцэтгэх захирал М.Өлзийбатыг эцсийн өмчлөгчөөр бүртгүүлж хуулийн этгээдийн гэрчилгээнд бичилт хийлгэсэн. Удирдах зөвлөлийн 10 тогтоол гарч тогтоол шийдвэрийн хэрэгжилт 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

2. Сүүлийн хагас жилийн хугацаанд ирсэн явсан бичиг, хүлээн авсан өргөдөл, гомдлыг хянаж үзэхэд 56 албан бичиг хүлээн авч 114 албан бичиг явуулсан байна. 15 хариутай албан бичиг ирсэнээс Даатгалын санд 3, Мэдээллийн санд 12 албан бичиг ирсэн байна. Даатгалын сан хугацаандаа багтаан хариу илгээж Мэдээллийн сан Монре даатгал ХХК, Мастер шийдэл ХХК, Смарткар ХХК болон Улаанбаатар хотын даатгал зэрэг байгууллагаас мэдээ хүсэх тухай, АРІ холболт хийх, системийн хөгжүүлэлт хийх, хамтран ажиллах гэрээ байгуулах зэрэг санал ирүүлсэн 4 бичигт хариу өгөлгүй хугацаа хэтрүүлснийг сануулж хариуг илгээсэн. Гүйцэтгэх захирлын 59 тушаал гарсныг хянаж ажилласан. Даваа гараг бүр шуурхай зөвлөгөөн хийж хийсэн ажил, Гүйцэтгэх захирлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцэж ажилладаг.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

Ажлын албаны дотоод хяналт хариуцсан

ахлах ажилтан

Б.Эрдэнэцэцэг

ТАЙЛАН БИЧСЭН:

Даатгалын сангийн дарга, ерөнхий санхүүч

С.Хишигзаяа

Мэдээллийн сангийн дарга

Т.Шинэцэрэг

Шуурхай албаны дарга

ХЯНАСАН:

Албан журмын даатгагчдын
холбооны гүйцэтгэх захирал

М.ӨЛЗИЙБАТ